ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД: СНАГ-2023/352/НА-СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

**Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг**
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
**Аудитын менежер: Ч.Болд**
Утас: 261205 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
**Ахлах аудитор: Р.Цолмон**
Утас: 261205 Цахим хаяг: tsolmonr@audit.gov.mn
**Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Бодьтусгал-Аудит ХХК**
Утас: 99080074 Цахим хаяг: boditusgal.audit@gmail.com

Улаанбаатар хот

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ....9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ....14
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ....16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ....16
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ....16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....17
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ....17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ....18
**3.5.1 Төсвийн төлөвлөлт ....18**
**4. АУДИТЫН ТАЙЛАН ....20**
**4.1 Ерөнхий зүйл** ....20
4.2 Материаллаг байдал ....20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ....20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....20
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ....20**
**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд ....21**
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....21
**4.5.1 Завсрын аудитын талаар ....21**
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....22
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ....23**
5.1 Албан шаардлага ....23
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....0

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| ДЭМБ | Дэлхийн эрүүл мэндийн байгууллага |
| ЗӨСҮТ | Зоонозын өвчин судлалын үндэсний төв |
| СНАГ | Санхүү-нийцлийн аудитын газар |
| ТБОНӨХБАҮХАТ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар |
| ЭМДС | Эрүүл мэндийг даатгалын сан |
| НӨАТ | Нэмэгдсэн өртгийн албан татвар |

Утас
Факс
Цахи
Цахи
Хаяг:
Бага
Улаа

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2023.02.20 № 07/340

танай ________ -ны № ________ -т

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ Н.ЦОГБАДРАХ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 43,874.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 8,822.6 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлаас 21,405.3 мянган төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн А/171 дугаар тушаалаар Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дэргэдэх эрүүл мэндийн салбарын нөөцийн агуулахын дүрэм, бүтэц, хүний нөөцийн ажлын байрны чиг үүргийг баталсан байна.

**Аудитын гол асуудал**

ЭМЯ-наас 2,959,029.4 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, 2,831,779.1 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, сэлбэг хэрэгсэл, хангамжийн материал хүлээн авсан байна.

### Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 52 … хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 80.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлага… байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй бол…

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай … Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн … улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг … илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорх… хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх матери… буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэсл… баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилт…

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түв… баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материалла… илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дан… эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн за… шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

Утас
Факс
Цахи
Цахи
Хаяг
Бага
Улаа

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,348,851,783.48** | **3,643,309,405.57** |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 1,348,851,783.48 | 3,643,309,405.57 |
| 351 | **Түүхий эд материал** | 1,153,408,599.38 | 3,094,361,521.65 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 201,299,626.00 | 1,136,333,120.50 |
| 35130 | Эм боох материал | 952,108,973.38 | 1,958,028,401.15 |
| 354 | **Хангамжийн материал** | **195,443,184.10** | **548,947,883.92** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 24,774,406.46 | 43,164,846.46 |
| 35420 | Аж ахуйн материал | 122,783,541.12 | 372,445,599.42 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 11,309,560.00 | 60,473,916.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 8,993,701.76 | 9,812,772.28 |
| 35450 | Барилгын засварын материал | 11,172,685.00 | 39,087,685.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 16,409,289.76 | 23,963,064.76 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,915,534,415.48** | **9,240,444,916.69** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 4,915,534,415.48 | 9,240,444,916.69 |
| 392 | **Биет хөрөнгө** | 4,165,809,665.48 | 8,474,013,916.69 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,970,307,124.00 | 2,733,992,779.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (403,301,271.80 ) | (552,514,495.28) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 1,771,969,395.80 | 1,881,343,580.80 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (458,847,493.62 ) | (455,847,161.82) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 3,292,919,380.74 | 5,291,324,877.79 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (2,097,404,269.34) | (740,907,289.19) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 301,260,425.01 | 448,073,851.11 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (211,093,625.31) | (131,898,777.49 ) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 446,551.76 | 446,551.77 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (446,551.76) | - |
| 393 | **Биет бус хөрөнгө** | 749,724,750.00 | 766,431,000.00 |
| 39301 | Програм хангамж | 18,444,567.10 | 36,264,567.10 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (18,444,567.10) | (19,558,317.10) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 749,724,750.00 | 749,724,750.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **6,264,386,198.96** | **12,883,754,322.26** |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **6,264,386,198.96** | **2,883,754,322.26** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 6,264,386,198.96 | 12,883,754,322.26 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,698,660,655.49 | 2,698,660,655.49 |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ӨӨРЧЛӨЛТГҮЙ

| Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан | | | |
|---|---|---|---|
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | 2,698,660,655.49 | 2,698,660,655.49 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,290,773,013.17 | 6,951,385,739.58 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,607,303,586.72 | 2,296,646,013.17 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 683,469,426.45 | 4,654,739,726.41 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,274,952,530.30 | 3,233,707,927.19 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **6,264,386,198.96** | **12,883,754,322.26** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **8,783,421,926.42** | **11,548,878,108.71** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,743,164,744.86** | **5,814,663,828.91** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,743,164,744.86 | 5,814,663,828.91 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,743,164,744.86 | 5,814,663,828.91 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 115,004,161.00 | 23,855,408.20 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 3,628,160,583.86 | 5,790,808,420.71 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **5,040,257,181.56** | **5,734,214,279.80** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,742,127,900.00 | 3,034,561,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,742,127,900.00 | 3,034,561,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,298,129,281.56 | 2,699,653,279.80 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 264,596,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 184,500.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,023,831,751.56 | 54,811,190.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 274,113,030.00 | 2,380,246,089.80 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **5,528,859,065.73** | **6,288,017,244.57** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,528,859,065.73** | **6,288,017,244.57** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 5,113,607,189.90 | 6,054,591,481.23 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,150,505,282.23 | 2,412,020,848.12 |
| 210101 | Үндсэн цалин | 1,075,032,242.34 | 1,263,951,683.74 |
| 210102 | Нэмэгдэл | 837,669,330.64 | 772,401,494.31 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 109,088,291.91 | 90,163,690.06 |
| 210104 | Урамшуулал | 128,715,417.34 | 285,503,980.01 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 316,791,753.50 | 312,737,901.46 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 236,809,274.66 | 234,893,648.96 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 16,790,038.04 | 18,997,195.10 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 26,605,910.35 | 17,339,238.57 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,326,175.54 | 3,842,174.66 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 33,260,354.91 | 37,665,644.17 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 107,717,103.54 | **138,668,749.49** |

ТӨРИЙН ... БАЙГУУЛЛАГА
01
ӨӨРЧЛӨЛТГҮЙ

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 57,777,966.17 | 59,598,101.64 |
| 210302 | Түлш, халаалт | 34,504,396.37 | 39,130,263.85 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 15,434,741.00 | 39,940,384.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 90,770,517.00 | 186,200,151.99 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,856,810.00 | 26,545,460.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 65,359,359.00 | 90,868,161.48 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,958,130.00 | 6,129,491.39 |
| 210404 | Ном, хэвлэл | | 6,250,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 11,596,218.00 | 12,799,990.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 4,866,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | | 38,741,049.12 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,526,394,560.08 | 1,013,835,615.14 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,517,706,560.08 | 1,005,135,615.14 |
| 210502 | Хоол, хүнс | 5,382,000.00 | 5,300,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,306,000.00 | 3,400,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 16,709,550.00 | 56,915,600.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,239,150.00 | 1,836,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 15,470,400.00 | 55,079,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9,072,040.00 | 104,872,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,072,040.00 | 104,872,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 330,474,251.00 | 1,080,268,456.20 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 292,752,065.00 | 1,032,551,974.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 3,500,000.00 | 2,786,750.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 11,150,200.00 | 2,079,454.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,277,400.00 | 1,277,400.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 323,356.00 | 352,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,449,750.00 | 21,384,397.20 |
| 210807 | Газрын төлбөр | 6,388,680.00 | 6,388,681.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 200,000.00 | 200,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 7,432,800.00 | 13,247,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 565,172,132.55 | 749,071,658.83 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 45,000,000.00 | 25,905,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 28,850,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 520,172,132.55 | 694,316,658.83 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 415,251,875.83 | 233,425,763.34 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 377,622,100.00 | 105,377,739.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 144,200,000.00 | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 10,017,100.00 | 103,461,939.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 223,405,000.00 | 1,915,800.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 37,629,775.83 | 121,932,685.46 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 37,629,775.83 | 121,932,685.46 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 6,115,338.88 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 6,115,338.88 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **3,254,562,860.69** | **5,260,860,864.14** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 2,571,093,434.24 | 606,121,137.73 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 2,571,093,434.24 | 606,121,137.73 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (2,571,093,434.24) | (606,121,137.73) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **683,469,426.45** | **4,654,739,726.41** |

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,698,660,655.49** | **1,302,168,530.30** | **1,580,087,586.72** | **5,580,916,772.51** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 27,216,000.00 | 27,216,000.00 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,698,660,655.49 | 1,302,168,530.30 | 1,607,303,586.72 | 5,608,132,772.51 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0.00 | (27,216,000.00) | 0.00 | (27,216,000.00) |
| Тайлант үеийн үр дүн | | | 683,469,426.45 | 683,469,426.45 |
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,698,660,655.49** | **1,274,952,530.30** | **2,290,773,013.17** | **6,264,386,198.96** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 5,873,000.00 | 5,873,000.00 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,698,660,655.49 | 1,274,952,530.30 | 2,296,646,013.17 | 6,270,259,198.96 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 1,958,755,396.89 | 0.00 | 1,958,755,396.89 |
| Тайлант үеийн үр дүн | | | 4,654,739,726.41 | 4,654,739,726.41 |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,698,660,655.49** | **3,233,707,927.19** | **6,951,385,739.58** | **12,883,754,322.26** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **5,155,261,342.56** | **5,758,069,688.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **115,004,161.00** | **23,855,408.20** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **115,004,161.00** | **23,855,408.20** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **115,004,161.00** | **23,855,408.20** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 115,004,161.00 | 23,855,408.20 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **5,040,257,181.56** | **5,734,214,279.80** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **2,742,127,900.00** | **3,034,561,000.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,742,127,900.00 | 3,034,561,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **2,298,129,281.56** | **2,699,653,279.80** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 0 | 264,596,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 184,500.00 | 0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,511,361,751.56 | 46,567,921.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 291,690,030.00 | 2,388,489,358.80 |
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | 494,893,000.00 | 0 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,030,854,642.56** | **5,662,500,288.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,030,854,642.56** | **5,662,500,288.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **4,615,602,766.73** | **5,429,074,524.66** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **2,150,505,282.23** | **2,412,020,848.12** |
| 210101 | Үндсэн цалин | 1,075,032,242.34 | 1,263,951,683.74 |
| 210102 | Нэмэгдэл | 837,669,330.64 | 772,401,494.31 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 109,088,291.91 | 90,163,690.06 |
| 210104 | Урамшуулал | 128,715,417.34 | 285,503,980.01 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **316,791,753.50** | **312,737,901.46** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 236,809,274.66 | 234,893,648.96 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 16,790,038.04 | 18,997,195.10 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 26,605,910.35 | 17,339,238.57 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,326,175.54 | 3,842,174.66 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 33,260,354.91 | 37,665,644.17 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **107,717,103.54** | **138,668,749.49** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 57,777,966.17 | 59,598,101.64 |
| 210302 | Түлш, халаалт | 34,504,396.37 | 39,130,263.85 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 15,434,741.00 | 39,940,384.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **86,467,226.46** | **171,202,623.39** |
| 210401 | Бичиг хэрэг | 26,265,596.46 | 41,736,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 43,125,500.00 | 91,687,232.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,958,130.00 | 6,129,491.39 |
| 210404 | Ном, хэвлэл | 0 | 6,250,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 11,118,000.00 | 15,399,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 0 | 10,000,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **1,528,513,600.00** | **1,054,375,146.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,507,931,600.00 | 1,034,407,146.00 |
| 210502 | Хоол, хүнс | 5,382,000.00 | 5,300,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 15,200,000.00 | 14,668,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **37,557,400.00** | **55,054,100.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 14,450,000.00 | 3,942,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 23,107,400.00 | 51,111,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **12,426,600.00** | **104,872,500.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 12,426,600.00 | 104,872,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **330,623,801.00** | **1,101,867,656.20** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 292,752,065.00 | 1,052,401,974.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 3,500,000.00 | 2,786,750.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 11,150,200.00 | 2,079,454.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,277,400.00 | 1,277,400.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 323,356.00 | 352,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,972,400.00 | 21,734,397.20 |
| 210807 | Газрын төлбөр | 6,388,680.00 | 6,388,681.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 200,000.00 | 200,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 7,059,700.00 | 14,647,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **45,000,000.00** | **78,275,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 45,000,000.00 | 50,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0 | 28,275,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **415,251,875.83** | **233,425,763.34** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **377,622,100.00** | **105,377,739.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 144,200,000.00 | 0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 10,017,100.00 | 103,461,939.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 223,405,000.00 | 1,915,800.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **37,629,775.83** | **128,048,024.34** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 24,164,775.83 | 121,932,685.46 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 13,465,000.00 | 6,115,338.88 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **124,406,700.00** | **95,569,400.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **124,406,700.00** | **95,569,400.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **124,406,700.00** | **95,569,400.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **124,406,700.00** | **95,569,400.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 124,406,700.00 | 95,569,400.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(124,406,700.00)** | **(95,569,400.00)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **0** | **0** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | **0** | 0 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | **0** | 0 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,053,192,700.00** | **2,936,790,952.74** | **116,401,747.26** | **96.2** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,926,409,700.00** | **2,831,413,213.74** | **94,996,486.26** | **96.8** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **887,892,700.00** | **823,806,901.88** | **64,085,798.12** | **92.8** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,808,755,800.00** | **1,785,869,570.42** | **22,886,229.58** | **98.7** |
| 210101 | Үндсэн цалин | 1,051,652,300.00 | 954,628,034.73 | 97,024,265.27 | 90.8 |
| 210102 | Нэмэгдэл | 472,195,100.00 | 573,904,389.81 | (101,709,289.81) | 121.5 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 125,730,000.00 | 83,272,901.95 | 42,457,098.05 | 66.2 |
| 210104 | Урамшуулал | 159,178,400.00 | 174,064,243.93 | (14,885,843.93) | 109.4 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **229,761,200.00** | **221,736,741.44** | **8,024,458.56** | **96.5** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 158,044,300.00 | 154,251,327.84 | 3,792,972.16 | 97.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,887,600.00 | 16,599,305.34 | 1,288,294.66 | 92.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 14,476,700.00 | 14,487,981.63 | (11,281.63) | 100.1 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,577,500.00 | 3,379,491.74 | 198,008.26 | 94.5 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 35,775,100.00 | 33,018,634.89 | 2,756,465.11 | 92.3 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **117,543,400.00** | **73,668,749.49** | **43,874,650.51** | **62.7** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 55,914,100.00 | 40,619,180.80 | 15,294,919.20 | 72.6 |
| 210302 | Түлш, халаалт | 52,495,100.00 | 26,788,262.69 | 25,706,837.31 | 51.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,134,200.00 | 6,261,306.00 | 2,872,894.00 | 68.5 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **74,315,400.00** | **73,262,373.39** | **1,053,026.61** | **98.6** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,866,700.00 | 2,866,700.00 | - | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 39,387,000.00 | 39,386,982.00 | 18.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,662,500.00 | 5,609,491.39 | 1,053,008.61 | 84.2 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 15,399,200.00 | 15,399,200.00 | - | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,000,000.00 | 10,000,000.00 | - | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | **486,599,600.00** | **485,949,600.00** | **650,000.00** | **99.9** |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ӨӨРЧЛӨЛТГҮЙ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 471,931,600.00 | 471,281,600.00 | 650,000.00 | 99.9 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 14,668,000.00 | 14,668,000.00 | - | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **93,964,600.00** | **89,803,500.00** | **4,161,100.00** | **95.6** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 71,576,300.00 | 67,749,400.00 | 3,826,900.00 | 94.7 |
| 210602 | Тавилга | 10,000,000.00 | 10,000,000.00 | - | 100.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 4,242,300.00 | 3,942,300.00 | 300,000.00 | 92.9 |
| 210604 | Урсгал засвар | 8,146,000.00 | 8,111,800.00 | 34,200.00 | 99.6 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **12,556,900.00** | **7,032,500.00** | **5,524,400.00** | **56.0** |
| 210702 | Дотоод албан томилолт | 12,556,900.00 | 7,032,500.00 | 5,524,400.00 | 56.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **72,912,800.00** | **64,090,179.00** | **8,822,621.00** | **87.9** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 31,555,900.00 | 24,017,294.00 | 7,538,606.00 | 76.1 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 4,000,000.00 | 2,786,750.00 | 1,213,250.00 | 69.7 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,150,200.00 | 2,079,454.00 | 70,746.00 | 96.7 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,277,400.00 | 1,277,400.00 | - | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 352,000.00 | 352,000.00 | - | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 24,554,400.00 | 24,554,400.00 | - | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 6,388,700.00 | 6,388,681.00 | 19.00 | 100.0 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 200,000.00 | 200,000.00 | - | 100.0 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 2,434,200.00 | 2,434,200.00 | - | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 30,000,000.00 | 30,000,000.00 | - | 100.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,000,000.00 | 30,000,000.00 | - | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **126,783,000.00** | **105,377,739.00** | **21,405,261.00** | **83.1** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **126,783,000.00** | **105,377,739.00** | **21,405,261.00** | **83.1** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 124,867,200.00 | 103,461,939.00 | 21,405,261.00 | 82.9 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,915,800.00 | 1,915,800.00 | - | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **3,053,192,700.00** | **2,936,483,722.74** | **116,708,977.26** | **96.2** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **3,034,561,000.00** | **2,912,628,314.54** | **121,932,685.46** | **96.0** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 3,034,561,000.00 | 2,912,628,314.54 | 121,932,685.46 | 96.0 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **18,631,700.00** | **23,855,408.20** | **(5,223,708.20)** | 128.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 18,631,700.00 | 23,855,408.20 | (5,223,708.20) | 128.0 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 | - | **100.0** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | - | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 103 | 96 | 7 | 93.2 |
| 620001 | Удирдах ажилтан | 3 | 4 | (1) | 133.3 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 86 | 92 | (6) | 107.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 14 | | 14 | - |

АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ӨӨРЧЛӨЛТГҮЙ

## 2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **2,693,230,710.92** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **2,693,230,710.92** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **2,693,230,710.92** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 626,151,277.70 |
| 210101 | Үндсэн цалин | | 309,323,649.01 |
| 210102 | Нэмэгдэл | | 198,497,104.50 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 6,890,788.11 |
| 210104 | Урамшуулал | | 111,439,736.08 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 91,001,160.02 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 80,642,321.12 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 2,397,889.76 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 2,851,256.94 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 462,682.92 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 4,647,009.28 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | 65,000,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 18,978,920.84 |
| 210302 | Түлш, халаалт | | 12,342,001.16 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 33,679,078.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 97,940,250.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 38,870,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 52,300,250.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 520,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | 6,250,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | | 568,425,546.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 563,125,546.00 |
| 210502 | Хоол, хүнс | | 5,300,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 43,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | | 43,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | 97,840,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 97,840,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 1,055,597,477.20 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 1,028,384,680.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 14,999,997.20 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | 12,212,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 48,275,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 20,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 28,275,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | 2,699,653,279.80 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 2,699,653,279.80 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 264,596,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 46,567,921.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 2,388,489,358.80 |

ТОРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ӨӨРЧЛӨЛТГҮЙ

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны эрхэм зорилгоо "Зоонозын халдварт өвчнийг тандах, хянах, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг судалгаа, нотолгоонд тулгуурлан мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж, халдварын эрсдлийг багасгах замаар хүн амын өвчлөл эндэгдэлийг бууруулах"-д оршино гэж тодорхойлсон байна.

Тус байгууллага нь Улсын хэмжээнд зоонозын халдварт өвчнүүдийг тандах, хянах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг оновчтой зохион байгуулах, зоонозын өвчний тархалтын тандалт судалгааг хийх, хүн амыг уг халдварт өртөх эрсдэлээс сэргийлэх, зоонозын халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал боловсруулж төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, зоонозын өвчний байгаль дахь тархалт цар хүрээ, идэвхжилийг тогтоож, эрсдэлийн дагуу бүсчлэх, зоонозын өвчний дэгдэлтийн үед голомтод эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг оновчтой зохион байгуулах, чиг үүргийн хүрээнд орон нутгийн харьяа байгууллагууд болон бусад эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, лабораторийн лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлэх, зоонозын халдварт өвчний мэдээллийн санг бүрдүүлэх"-д мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Тайлант оны онцлог үйл явдлууд:

- Эрүүл мэндийн сайдын 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн А/309 тоот тушаалаар төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор шинээр нээгдсэн нөөцийн агуулахад ажиллах орон тоо, төсвийг 2022 оны төсөвт нэмж өөрчлөлт оруулсан байна.
- ДЭМБ-ын төсөл "Хүн, мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах бодлогын үнэлгээний салбар хоорондын хэлэлцүүлэг"-ийн бэлтгэл ажлын зардлын санхүүжилтэд 159,925.0 мянган төгрөг, НҮБ-ын хүүхдийн сангийн " Халдвараас сэргийлэх хяналтын чадавхжуулах сургалт"-ын 74,671.0 мянган төгрөг, ЭМДэмжих сангийн төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд 156,083.8 мянган төгрөгийг тус тус хүлээн авч зарцуулсан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд голлон мөрдөх дараах хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон. Тухайлбал:

- Хөдөлмөрийн тухай хууль;
- Төрийн хэмнэлийн тухай хууль;
- ЗГ-ын 2022 оны 107 дугаар тогтоол "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай";
- Эрүүл мэндийн тухай хууль;
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль
- Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 49, А/118 дугаар тушаал "төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай" тушаал;
- ЭМҮЗөвлөлийн 12 дугаар тогтоол "Журам шинэчлэн батлах тухай"

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Байгууллага нь дотоод хяналтын ажилтныг 2022 оны 9 дүгээр сард томилон ажиллуулж 4 дүгээр улиралд дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн байна.

Үүнд: 1. Байгууллагын санхүүгийн харилцах, касс, бараа материал, худалдан авалт, тендерийн үйл ажиллагаанд хяналт тавьж шалгалтын ажлыг зохион байгуулан зөвлөмж өгөх

2. Төсвийн тухай хууль, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих.

3. Цалингийн тооцоолол, НДШ, ХХОАТ-ын тайланд хяналт тавих.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

ЭМЯамны хяналт шалгалт, үнэлгээ дотоод аудитын газраас тус байгууллагын 2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийжээ. Тус шалгалтын дүгнэлт, тайлан тухайн байгууллагад хүргэгдэн ирээгүй байн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохисон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,619,368.1 мянган төгрөгөөр буюу 105.7 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 1,348,851.8 | 3,643,309.4 | 2,294,457.6 |
| Үндсэн хөрөнгө | 4,915,534.4 | 9,240,444.9 | 4,324,910.5 |
| Нийт хөрөнгө | 6,264,386.2 | 12,883,754.3 | 6,619,368.1 |
| Хуримтлагдсан үр дүн | 2,290,773.0 | 6,951,385.7 | 4,660,612.7 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 6,264,386.2 | 12,883,754.3 | 6,619,368.1 |

Дансны үлдэгдэлд дараах материаллаг дүнтэй өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

Бараа материалын дансны үлдэгдэл 3,643,309.4 мянган төгрөг болж өмнөх оноос 2,294,457.6 мянган төгрөгөөр өссөн нь Ковидтой холбоотойгоор "Арга хэмжээ авч ажиллах тухай" Эрүүл мэндийн сайдын 2021 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 2/3389 тоот, 2021 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 1А/1700 тоот албан бичгээр /3-5 сарын нөөцийн бүрдүүлэлттэй байхаар/ өгсөн чиглэлийн дагуу эм, эмнэлгийн хэрэгсэл, бусад бараа материалын 1,476,462.5 мянган төгрөгийн худалдан авалт хийж, хандиваар 2,831,779.1 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авч нэмэгдүүлснээс шалтгаалсан байна.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ӨӨРЧЛӨЛТГҮЙ

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 9,240,444.9 мянган төгрөг болж урд оноос 4,324,910.5 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд төсвийн хөрөнгөөр машин тоног төхөөрөмж 67,749.4 мянган, тавилга эд хогшил 10,000.0 мянган, нөөцийн агуулахад санхүүгийн программ 17,820.0 мянган төгрөгөөр худалдан авсан, Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар болон хандиваар нийт 2,959,029.4 мянган төгрөгийн барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тавилга аж ахуйн эд хогшил үнэ төлбөргүйгээр авсантай холбоотой байна. Тайлангаар Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2022 оны шийдвэрийг үндэслэн 18,500.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгслийг акталж данс бүртгэлээс хассан байна

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 12,883,754.3 мянган төгрөг болж, өссөн нь тайлант оны үр дүн нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,352,157.5 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний зардалд 4,162,761.5 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлэгт 189,396.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Эрүүл мэндийн яамнаас хуваарилсан төсвийн дагуу нийт зардлыг 3,053,192.7 мянган төгрөгт багтаан зарцуулахаар, ажиллагсдын тоог 110 орон тоотой байхаар баталж, хуваарь хийж ирүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 3,034,561.0 мянга, туслах үйл ажиллагаанаас 18,631.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,034,561.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлогоос 23,855.4 мянга, даатгалын төлбөрөөс 307.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 2,936,790.9 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж үлдэгдэл 121,932.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,936,790.9 мянган төгрөг буюу 96.2 хувьтай байгаа нь цалин хөлстэй холбоотой зардлыг 30,910.7 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 43,874.6 мянга, хангамж, бараа материалын зардлыг 1,053.0 мянга, нормативт зардлыг 650.0 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 4,161.1 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 8,822.6 мянга, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлыг 21,405.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

*/мянган төгрөгөөр/*

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 71601 Нийгмийн эрүүл мэнд | 3,053,192.7 | 2,936,790.9 | 116,401.8 | 96.2 |
| 1.1 | 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал | 2,926,409.7 | 2,831,413.2 | 94,996.5 | 96.8 |
| 1.2 | 80802-Бусад урсгал шилжүүлэг | 126,783.0 | 105,377.7 | 21,405.3 | 83.1 |
| | **Дүн** | 3,053,192.7 | 2,936,790.9 | 116,401.8 | 96.2 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 46,567.9 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 2,388,489.4 мянган төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаас 264,596.0 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр олж урсгал үйл ажиллагаанд 2,693,230.7 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 6,115.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах, төсвийн зарцуулалтыг сайжруулж хэмнэлттэй ажиллах, хууль дүрэм журмыг мөрдөж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Бодьтусгал-Аудит ХХК-ийн аудитор С.Батгэрэл, Г.Юмчмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал З.Мягмарсүрэн хэрэгжүүлсэн.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Бодьтусгал-Аудит ХХК-д 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 1/44 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 5,528,859.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 82,932.9 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын цахилгаан халаалтын температурыг ажлын бус цагаар багасгаж тог цахилгааныг хэмнэх зохицуулалт хийж, байгууллаас зохион байгуулах сургалт, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулах зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.
Энэ хуулийн хүрээнд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 43,874.6 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардлаас 5,524.4 мянган төгрөгийг хэмнэхээс гадна бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч нийт 116,401.8 мянган төгрөгөөр хэмнэлт гаргасан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий